



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/22

Сүхбаатар сум

Зорчих хөдөлгөөнийг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л", 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Автотээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, Улсын Онцгой Комиссын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн "Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох тухай" 10 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сар 21-ний өдрийн 45 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад коронавирус /Covid-19/-ийн халдвар бүртгэгдсэн тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварын тархалтаас хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 21:00 цагаас 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд аймаг, сумын төвөөс гарах, орох чиглэлд иргэд, автомашин, суудлын галт тэрэгний зорчих хөдөлгөөнийг түр зогсоосугай.

2. Заасан хугацаанд сум, орон нутагтаа орох, гарах чиглэлийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоож, байнгын эргүүл, шалгалтын ажлыг зохион байгуулж, холбогдон гарах зардлыг сумандаа шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.


3. Хүндэтгэн үзэх шалтгаантай, гарцаагүй байдлын улмаас аймаг, сумаас гарах, орох шаардлагатай иргэдийн хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-д даалгасугай.

4. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан дүрэм, журам, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, банкаар үйлчлүүлж буй иргэдийг олноор нь бөөгнөрөл үүсгэхгүйгээр үйлчилгээ үзүүлэх, ариутгал халдваргүйтгэлийг тухай бүр хийх зсхион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг банкны төв, салбарын захирал, эрхлэгч нарт даалгасугай.

5. Захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/,

аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, сумдын Засаг дарга нарт , иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ